

## УНГАР УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛЭГ

### Хөтөлбөрийн товч танилцуулга

Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Унгар Улсын Хүний Нөөцийн яам хооронд 2015 онд байгуулсан Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах хөтөлбөрийн хүрээнд тус тэтгэлэг явагдаж байна. Нийт элсүүлэх оюутны тоо 180-200

### Шалгуур үзүүлэлт

- Ахисан төвшний хөтөлбөр (Хугацаа: 1 дүгээр сар)

Тэтгэлгийн хугацаа	Магистрын зэрэг	2 жилийн хугацаатай сургалт
	Докторын зэрэг	2-5 жилийн хугацаатай сургалт
Шалгуур үзүүлэлт	<b>Сонгон шалгаруулалтанд оролцох хүн нь доор бичсэн шалгууруудыг хангах ёстой.</b>  <ol style="list-style-type: none"><li>Магистрантурт суралцах бол бакалаврын зэрэгтэй, 35 хүртэлх насны Монгол улсын иргэн байх;</li><li>Докторантурт суралцах бол магистрын зэрэгтэй, 40 хүртэлх насны Монгол улсын иргэн байх ;</li><li>Өмнө нь аль нэг улсын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаагүй байх;</li><li>Мэргэжлээрээ 2-3 жил ажилласан байх, Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт (Хэвлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлүүдийн жагсаалт, сонгосон чиглэлээр суралцах сэдвийн хүрээнд бичсэн автореферат; магистрын сургалтад өргөдөл гаргах иргэд хавсаргах шаардлагагүй ч хавсаргавал давуу талтай)</li><li>Олон улсад хүчинтэй гадаад хэлний шалгалт өгч хангалттай оноо авсан байх. IELTS 6.5 аас дээш</li></ol>	

- Бакалаврын хөтөлбөр(Хугацаа: 1 дүгээр сар)

Тэтгэлгийн хугацаа	Бакалаврын зэрэг	5 жилийн хугацаатай сургалт
Шалгуур	<b>Сонгон шалгаруулалтанд оролцох хүн нь доор бичсэн шалгууруудыг хангах ёстой;</b>	

## ҮЗҮҮЛЭЛТ

1. Өргөдөл гаргагч нь 17-25 нас хүртэлх Монгол улсын иргэн байх.
2. Өмнө нь аль нэг улсын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаагүй байх.
3. Бүрэн дунд боловсролын гэрчилгээний дундаж үнэлгээний голч дүн 80-аас дээш, их дээд сургуулийн 1-2-р курст суралцдаг бол голч дүн 3,0 ба түүнээс дээш байх.
4. Олон улсад хүчинтэй гадаад хэлний шалгалт өгч хангалттай оноо авсан байх. IELTS 6.5 аас дээш

## Сонгон шалгаруулалтын үйл явц

1



Нэгдүгээр шатны шалгаруулалт: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам Унгарын талаас ирүүлсэн Монгол иргэдийн анкет, баримт бичигт үнэлгээ өгч, тогтоосон тоонд багтаан нэр дэвшигчийг шалгаруулна.

2



Хоёрдугаар шатны шалгаруулалт: нэгдүгээр шатны шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигч өөрийн сонгосон (3 хүртэлх) сургуулийн элсэлтийн шалгалтыг дөрөв тавдугаар сард өгнө.

3



Сургууль бүрийн шалгалт авах хугацаа, хэлбэр өөр тул тухайн сургууль нь шалгалтын тухай мэдээллийг нэр дэвшигчдэд өөрт нь хувийн цахим шуудангаар нь ирүүлнэ. БСШУСЯ энэхүү шалгалтын үйл ажиллагаанд оролцдоггүй тул нэр дэвшигч өөрийн цахим шууданг тогтмол шалган, хариу бичих, харилцаа холбоо хийх үүргийг хүлээнэ.



Шалгаруулалтад тэнцсэн хариу авсан иргэн тэтгэлгийн нөхцлийг хүлээн зөвшөөрч, суралцах тухай хариуг Тэтгэлгийн хороонд VI-VII сарын дотор хариу мэдээлэх үүрэгтэй. Тэтгэлгээр суралцах эрх авсан иргэн визанд орно.

Дэлгэрэнгүй мэдээллийг авах бол

- [www.stipendiumhungaricum.hu](http://www.stipendiumhungaricum.hu)